

World Congress on Integrated Care 2014, Sydney, November 23-26, 2014

International Journal of Integrated Care” ISSN 1568-4156

Volume 14, 8 December 2014

Publisher: Igitur publishing

URL: <http://www.ijic.org>

Cite this as: Int J Integ Care 2014; WCIC Conf Suppl; URN:NBN:NL:UI:10-1-116659

Эрүүл Мэндийн Нийгмийн Ажилтан нь өндөр эрсдэлтэй

мэдрэлийн өвчтөнд үйлчлэх нь

Medical Social Worker (MSW) as case manager for high risk neurology patients

Хураангуй

Үндэслэл

Бруней улсын хүн амын дотор мэдрэлийн өвчин нь маш өргөн тархснаар тухайн орон энэ өвчний хамгийн өндөр хувийг эзлээд байна. Ийм үед хувь хүн бүр хязгаарлалтын өргөн хүрээ тогтоож, өндөр эрсдэлтэй өвчтнүүдээс хол байх нь зүйтэй.

Бидний ажлын нэг гол онцлог нь тухайн асуудлыг хүлээн зөвшөөрч, өвчний аюулгүй байдлын талаар олон талт уулзалт зохион байгуулж, тухайн өвчтнүүддээ дэмжлэг үзүүлэх зорилготой. Гэсэн хэдий ч мэдрэлийн өвчин нь олон нийт рүү чиглэгдэн өвчтөнд маш олон бэрхшээлүүд тулгарсаар байна.

Зорилго:

Энэхүү судалгааны ажил нь Эрүүл мэндийн Нийгмийн ажилтны (MSW) үүрэг хариуцлагыг судлах, тэр дундаа өндөр эрсдэлтэй байгаа мэдрэлийн өвчтэй иргэдийн хүн ам зүйн өөрчлөлтийн байдал, тархи мэдрэлийн өвчтэй иргэдийг асрах баг хамт олны тэргүүн зорилгод нийцсэн үйлчилгээний шаардлагад гарч буй зөрчлийг илэрүүлэх явдал юм.

Аргазүй:

Эрүүл мэндийн Нийгмийн ажилтан нь 2013 оны 01 сарын 1-ээс 2013 оны 12 сарын 31-ийг хүртэлх хугацаанд “RIPAS” эмнэлгийн мэдрэлийн өвчтнүүдийг тасгийн өвчтөнүүдээс ялгахаар өвчтөний бүртгэлийн мэдээллийг ашиглаж Эрүүл мэндийн Нийгмийн ажилтны ажлын хэсэгт мэдэгдэж байсан. Түүнчлэн өвчтнүүдийн лавлагаа, өвчний шалтгаан, өвчтний асран хамгаалагчийн нөөц боломж болон өвчнийг эмчилэхэд гарах урсах зардал зэргийг төлөвлөн хүмүүст танилцуулж байсан. Бичиг баримтын хяналт

болон тооны системчилсэн үнэлгээ гаргах тохиолдолд дүн шинжилгээ хийж судалдаг байна. Хүн амзүйн болон оношлогооны мэдээллийг цуглуулсан байна.

Үр дүн

2013 онд бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн 450 өвчтнөөс 30 өвчтөн буюу 7% нь мэдрэлийн өвчтний халамжинд хамрагдсаныг Эрүүл мэндийн Нийгмийн ажилтан дурьдсан юм. 27 өвчтөн буюу 6% нь оролцооны шалгуурын өмнө ирчихээд байна. Энэхүү судалгааны ололттой тал нь эдийн засгийн асуудлууд, олон нийтийн нөөц, баялагийн хомсдол болон нийгмийн үйлчилгээн дэх оролцооны хязгаардлагдмал байдал гэх мэт зүйлс нь өвчтнийг олон нийтэд эргэн нэгтгэхэд хамгийн том саад учруулж байгааг харуулсан явдал юм. Судалгаанаас гарсан бэрхшээлийг “**International Journal of Integrated Care**” /World Congress on Integrated Care 2014, Sydney, November 23-26, 2014. International Journal of Integrated Care – Volume 14, 8 December – URN:NBN:NL:UI:10-1-116659– <http://www.ijic.org/> сэтгүүлд зөв мэдээллэж, түүнийг зөв ашиглах хэрэгтэй байна. Мөн “**International Journal of Integrated Care**” сэтгүүлээр дамжуулан өвчнүүдийн харилцааг олон нийтэд эргэн нэгтгэхэд чиглэгдэнэ.

Дүгнэлт

Мэдрэлийн өвчний үр дагавар гүнзгий шатандаа байгаа ба нийгмийн оролцоо, зохицуулалтыг бүрэн шаарддаг чухал үзүүлэлтүүд тэднийг зовоож байдаг. Ийм өвчтэй хүмүүс амьдралаас үүдэн гарсан бие махбодь болон нийгэм-сэтгэлзүй, танин мэдэхүйд гарч буй өөрчлөлт, биеэ авч явах байдал зэрэг асуудалтай тулгардаг. Эдгээр өөрчлөлтүүд нь тэднийг олон нийттэй дахин дасан зохицоход хүндрэлүүдийг бий болгодог. Энэхүү судалгаагаар илэрсэн саад бэрхшээлүүдийг албан ёсоор шийдвэрлэх шаардлагатай билээ.

Нийгмийн харилцаанд оролцож амжилтанд хүрэхийн тулд энэ судалгаа нь Эрүүл мэндийн Нийгмийн Ажилтны дүрэм, журмын талаар илүү ойлголт өгөхөд нэмэр оруулах. Тэр дундаа Бруней хот дахь мэдрэлийн өвчтэй хүмүүсийг дэмжих, туслах, зохицуулах мөн түүнчлэн харилцаанд хөндлөнгөөс саад болж байгаа хүчин зүйлсийг тогтоосон.

Энэ туршилтын ажил нь

- Брунейгийн эрүүл мэнд, халамжийн бодлогууд нэгдсэн дүрэм журамтай болохыг
- Эрүүл мэндийн Нийгмийн Ажилтны /MSW/ дүрэм журам нь нэгдмэл зүйл болохыг харуулж байна.

Энэ нь ирээдүйд төлөвлөгдөж байгаа эрүүл мэндийн болон нийгмийн тогтолцоонд гарах судалгааны ажилд ихээхэн боломжийг бий болгож байгаа юм.

Түлхүүр үг:

Эрүүл мэндийн нийгмийн ажил, саад бэрхшээл, олон нийтийг эргэн нийгэмшүүлэх , мэдрэл, урсах зардлын төлөвлөлт

Орчуулсан: Нийгмийн ажлын багш М.Чимгээ, Т.Чанцалдулам